# ХЭНТИЙ АЙМГИЙН НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 01 сарын 03 өдөр | Дугаар А/04 | Жаргалант

Хөтөлбөр боловсруулах
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.3, дахь заалт, Норовлин сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Хүн болох багаасаа” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч | Д.Шижирмөнх | Засаг даргын орлогч |
| Нарийн бичгийн дарга | Х.Ууганцэцэг | ЕБС-ийн захирал |
| Гишүүдэд | Э.Ононцэцэг | Санхүү албаны дарга |
| | Г.Баатархуяг | Нийгмийн бодлогын мэргэжилтэн |
| | Г.Туул | сургалтын менежер |
| | Д.Гантөр | сургалтын менежер |
| | Ө.Мөнхзаяа | Нийгмийн ажилтан |

2.”Хүн болох багаасаа” хөтөлбөрийг боловсруулахдаа хүүхдийн хөгжил, хүмүүжил, хамгааллын асуудлыг хамарсан, хэтийг харсан, хүрч болох зорилтуудыг дэвшүүлсэн, тэдгээрийг хэрэгжүүлэх орчин нөхцлийг бүрдүүлэх арга замыг тодорхой тусган боловсруулахыг ажлын хэсэг үүрэг болгосугай.

3.Хөтөлбөрийг 2025 оны 01 дүгээр сарын 15-ний дотор боловсруулж танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Шижирмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Ө.ДАВААЖАРГАЛ

D:bichig hereg /zahiramj-2025

23?501007

Боловсруулсан:
Хянасан:
Хувь
Олгосон